

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.01.31	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.01.31 № 2/01
танай _____-ны № _____-т
Г _____ Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2016 онд үүссэн авлагыг барагдуулаагүй, өмч хөрөнгөтэй холбоотой засварын ажлуудад өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй,

D- alban bichig 2022 A4 TOOT

5020051

худалдан авалтын и баримтад хяналт тавиагүй зэрэг зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



D- alban bichig 2022 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,076,505,029.73	1,043,427,937.16
33	АВЛАГА	30,000,000.00	30,000,000.00
335	Бусад авлага	30,000,000.00	30,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	30,000,000.00	30,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,046,505,029.73	1,013,427,937.16
351	Түүхий эд материал	2,333,327.27	2,380,137.27
35110	Тусгай зориулалттай материал	1,904,527.27	1,690,027.27
35130	Эм боох материал	428,800.00	690,110.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	273,893,700.00	139,133,700.00
354	Хангамжийн материал	631,956,220.46	666,302,616.89
35410	Бичиг хэргийн материал	1,721,900.00	952,540.00
35420	Аж ахуйн материал	35,841,923.88	33,755,115.88
35430	Сэлбэг хэрэгсэл	3,339,000.00	16,716,684.00
35440	Түлш, шатах тослох материал	2,378,640.00	5,964,965.00
35460	Хүнсний материал	250,800.00	180,000.00
35470	Бусад хангамжийн материал	588,423,956.58	608,733,312.01
35500	Биологийн хөрөнгө	136,221,782.00	203,511,483.00
35600	Мал амьтад	2,100,000.00	2,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,063,836,356.32	3,215,027,419.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,063,836,356.32	3,215,027,419.99
392	Биет хөрөнгө	3,425,114,756.32	2,523,152,859.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,283,848,359.64	1,292,983,359.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-512,902,104.94	-683,352,872.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,248,725,943.30	4,081,508,109.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,675,832,977.12	-2,264,269,790.53
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	299,497,176.00	350,519,846.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-229,825,717.56	-261,190,389.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,652,455.98	31,652,455.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,048,378.98	-24,697,858.90
393	Биет бус хөрөнгө	638,721,600.00	691,874,560.00
39301	Програм хангамж	1,525,000.00	1,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,525,000.00	-1,525,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	638,721,600.00	691,874,560.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,140,341,386.05	4,258,455,357.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,140,341,386.05	4,258,455,357.15
51	Засгийн газрын хувь оролцоо	5,140,341,386.05	4,258,455,357.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,156,582,358.27	1,156,582,358.27
51101	Өмч: - төрийн	1,156,582,358.27	1,156,582,358.27
512	Хуримтлагдсан үр дүн	3,617,695,947.81	2,735,809,918.91
51210	Өмнөх үеийн үр дүн	3,617,695,947.81	3,617,695,947.81
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-881,886,028.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	366,063,079.97	366,063,079.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,140,341,386.05	4,258,455,357.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,476,776,443.28	3,133,882,559.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,123,071,437.28	412,941,159.72
120	Нийтлэг татварын бус орлого	1,123,071,437.28	412,941,159.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,123,071,437.28	412,941,159.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,123,071,437.28	412,941,159.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,353,705,006.00	2,720,941,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,144,356,800.00	2,709,792,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,144,356,800.00	2,709,792,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,348,206.00	11,149,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	130,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,663,206.00	540,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,015,000.00	9,669,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,670,000.00	940,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,545,483,303.20	3,850,310,255.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,545,483,303.20	3,850,310,255.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,539,612,926.02	3,837,209,185.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,778,448,256.14	2,334,635,442.00
210101	Үндсэн цалин	1,119,459,243.14	1,609,783,813.00
210102	Нэмэгдэл	599,850,013.00	654,769,529.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,139,000.00	61,645,500.00
210104	Урамшуулал	00.00	8,436,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,268,800.00	70,688,758.68
210201	Тэтгэврийн даатгал	19,605,105.00	19,755,990.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,310,460.00	2,324,234.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,848,369.00	1,859,389.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,284.00	432,862.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,070,582.00	46,316,283.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,975,043.68	197,365,696.94
210301	Гэрэл, цахилгаан	14,751,659.98	17,095,055.74
210302	Түлш, халаалт	134,471,087.70	175,331,297.20
210303	Цэвэр, бохир ус	4,752,296.00	4,939,344.00
2104	Хангамж, бараа материалын зардал	102,893,912.00	104,035,143.49
210401	Бичиг хэрэг	12,031,300.00	5,207,000.00
210402	Тээвэр, шатахуун	75,472,414.00	81,030,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,011,000.00	4,599,935.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,271,420.00	8,651,100.00
210408	Бараа материал акталсны зардал	3,507,778.00	4,306,558.00
2105	Нормативт зардал	229,252,338.00	122,519,976.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,723,160.00	724,690.00
210502	Хоол, хүнс	46,432,239.00	49,471,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	173,096,939.00	72,324,136.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,553,500.00	34,867,347.29
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,866,500.00	2,676,019.29
210604	Урсгал засвар	72,687,000.00	32,191,328.00
2107	Томилолт, зочны зардал	1,543,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,543,200.00	00.00

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	372,128,284.00	163,153,422.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	363,451,676.00	155,154,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	558,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,412,175.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,859,812.00	2,383,416.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	539,000.00	682,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,500.00	1,058,000.00
210807	Газрын төлбөр	2,505,121.00	3,276,006.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	746,549,592.20	809,943,398.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,486,500.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	740,063,092.20	809,943,398.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,870,377.18	13,101,069.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	4,740,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	4,740,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,970,377.18	8,360,269.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,970,377.18	8,360,269.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-68,706,859.92	-716,427,695.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	165,458,333.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	165,458,333.35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-165,458,333.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-68,706,859.92	-881,886,028.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,353,705,006.00	2,720,941,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,353,705,006.00	2,720,941,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,144,356,800.00	2,709,792,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,144,356,800.00	2,709,792,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,348,206.00	11,149,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	130,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,663,206.00	540,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,015,000.00	9,669,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,670,000.00	940,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,346,461,206.00	2,720,941,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,346,461,206.00	2,720,941,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,340,590,828.82	2,707,840,330.11

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,778,448,256.14	2,334,635,442.00
210101	Үндсэн цалин	1,119,459,243.14	1,609,783,813.00
210102	Нэмэгдэл	599,850,013.00	654,769,529.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,139,000.00	61,645,500.00
210104	Урамшуулал	00.00	8,436,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,268,800.00	70,688,758.68
210201	Тэтгэврийн даатгал	19,596,705.00	19,755,990.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,310,460.00	2,324,234.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,848,369.00	1,859,389.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,284.00	432,862.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,078,982.00	46,316,283.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,407,858.68	198,813,571.94
210301	Гэрэл, цахилгаан	14,751,659.98	17,095,055.74
210302	Түлш, халаалт	132,903,902.70	176,779,172.20
210303	Цэвэр, бохир ус	4,752,296.00	4,939,344.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,257,200.00	14,712,535.49
210401	Бичиг хэрэг	5,894,800.00	4,989,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,011,000.00	4,599,935.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	600,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,251,400.00	4,883,600.00
2105	Нормативт зардал	47,773,700.00	45,341,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,011,900.00	986,000.00
210502	Хоол, хүнс	45,761,800.00	44,355,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,303,000.00	24,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,298,000.00	00.00
210604	Урсгал засвар	63,005,000.00	24,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,543,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,543,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	211,900,814.00	19,148,422.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,224,206.00	11,149,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	558,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,412,175.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,859,812.00	2,383,416.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	539,000.00	682,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,500.00	1,058,000.00
210807	Газрын төлбөр	2,505,121.00	3,276,006.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,688,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,688,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,870,377.18	13,101,069.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	4,740,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	4,740,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,970,377.18	8,360,269.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,970,377.18	8,360,269.89

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,243,800.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,243,800.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,243,800.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,243,800.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,243,800.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,243,800.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	863,022,001.47	1,479,593,315.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,739,176.06	5,739,176.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	868,761,177.53	1,485,332,491.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-5,739,176.06	00.00	-5,739,176.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,373,696.66	53,373,696.66
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	3,617,695,947.81	5,140,341,386.05
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	3,617,695,947.81	5,140,341,386.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	3,617,695,947.81	5,140,341,386.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-881,886,028.90	-881,886,028.90
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	2,735,809,918.91	4,258,455,357.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,709,792,400.00	2,701,432,130.11	8,360,269.89	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,709,792,400.00	2,701,432,130.11	8,360,269.89	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,705,051,600.00	2,696,691,330.11	8,360,269.89	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,335,233,500.00	2,334,635,442.00	598,058.00	100.0
210101	Үндсэн цалин	1,111,528,700.00	1,609,783,813.00	-498,255,113.00	144.8
210102	Нэмэгдэл	1,156,074,800.00	654,769,529.00	501,305,271.00	56.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,471,000.00	61,645,500.00	-19,174,500.00	145.1
210104	Урамшуулал	25,159,000.00	8,436,600.00	16,722,400.00	33.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,692,700.00	70,688,758.68	3,941.32	100.0
210201	Тэтгэврийн даатгал	20,148,300.00	19,755,990.68	392,309.32	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,370,300.00	2,324,234.00	46,066.00	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,896,400.00	1,859,389.00	37,011.00	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	474,100.00	432,862.00	41,238.00	91.3
210205	Эрүүл мэндийн даатгал	45,803,600.00	46,316,283.00	-512,683.00	101.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,027,300.00	198,813,571.94	7,213,728.06	96.5
210301	Гэрэл, цахилгаан	22,520,300.00	17,095,055.74	5,425,244.26	75.9
210302	Түлш, халаалт	178,540,100.00	176,779,172.20	1,760,927.80	99.0
210303	Цэвэр, бохир ус	4,966,900.00	4,939,344.00	27,556.00	99.4

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2104	Хангамж, бараа материалын зардал	14,766,700.00	14,712,535.49	54,164.51	99.6
210401	Бичиг хэрэг	4,989,000.00	4,989,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	4,599,935.49	64.51	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн уст	294,100.00	240,000.00	54,100.00	81.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,883,600.00	4,883,600.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	45,341,600.00	45,341,600.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	986,000.00	986,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	44,355,600.00	44,355,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,500,000.00	24,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	24,500,000.00	24,500,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,489,800.00	7,999,422.00	490,378.00	94.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,686,000.00	2,383,416.00	302,584.00	88.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	748,000.00	682,000.00	66,000.00	91.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,058,000.00	1,058,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	3,397,800.00	3,276,006.00	121,794.00	96.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4740800.00	4740800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,740,800.00	4,740,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,740,800.00	4,740,800.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,709,792,400.00	2,701,432,130.11	8,360,269.89	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,709,792,400.00	2,701,432,130.11	8,360,269.89	99.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,709,792,400.00	2,701,432,130.11	8,360,269.89	99.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	135.00	126.00	9.00	93.3
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	134.00	125.00	9.00	93.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	135.00	126.00	9.00	93.3
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	120.00	111.00	9.00	92.5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	209,348,206.00	11,149,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	209,348,206.00	11,149,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,348,206.00	11,149,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,348,206.00	11,149,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,348,206.00	11,149,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	209,348,206.00	11149000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,149,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	130,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,663,206.00	540,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,015,000.00	9,669,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,670,000.00	940,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх
- Гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, гамшиг судлалын шинжлэх ухаан, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Гамшгийн нэгдсэн удирдлага зохицуулалтыг сайжруулах, холбоо, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- Гал түймэртэй тэмцэх үйл тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах
- Стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах
- Улсын нөөцийн удирдлага, зохион байгуулалт, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулалтыг сайжруулах
- Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх
- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүх талын үйлчилгээг сайжруулах
- Төсөв санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ар тал, хангалт үйлчилгээг сайжруулах
- Дотоод аюулгүй байдлыг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 881,886.0 мянган төгрөг буюу 17.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,076,505.0	20.9%	1,043,427.9	24.5%	(33,077.1)	-3.1%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	30,000.0	0.6%	30,000.0	0.7%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	1,046,505.0	20.4%	1,013,427.9	23.8%	(33,077.1)	-3.2%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,063,836.4	79.1%	3,215,027.4	75.5%	(848,808.9)	-20.9%
Үндсэн хөрөнгө	6,503,970.5	126.5%	6,450,063.3	151.5%	(53,907.2)	-0.8%
Хуримтлагдсан элэгдэл	(2,440,134.2)	-47.5%	(3,235,035.9)	-76.0%	(794,901.7)	32.6%
Нийт хөрөнгө	5,140,341.4	100.0%	4,258,455.4	100.0%	(881,886.0)	-17.2%
Өр төлбөр	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,140,341.4	100.0%	4,258,455.4	100.0%	(881,886.0)	-17.2%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,140,341.4	100.0%	4,258,455.4	100.0%	(881,886.0)	-17.2%

Авлагын дансны үлдэгдэл 30,000.0 мянган төгрөг байгаа нь 2016 онд үүссэн Сод ноён ХХК-тай холбоотой үүссэн авлага бөгөөд тус байгууллагаас хууль хяналтын байгууллад шилжүүлсэн ч Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2955 дугаартай албан бичгээр гэмт хэргийн шинжгүй хэмээн дүгнэж 2022 оны 184 дугаартай тогтоолоор хэрэг бүртгэлийг хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,013,427.9 мянган төгрөг болж 33,077.1 мянган төгрөгөөр буур байна.

Төсвийн худалдан авалтаар 86,709.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн ИТХ-аас 9,100.0 мянга, Онцгой байдлын ерөнхий газраас 20,217.8 мянган төгрөгийн хангамжийн материал, 20,269.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 83,000.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 138,254.5 мянган төгрөгийн нормын хувцас хэрэглэл, 5,044.8 мянган төгрөгийн хүнсний материал, 10,410.0 мянган төгрөгийн эм боох материал нийт 86,709.2 мянган төгрөгийн

материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 268,743.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бэлэн бүтээгдэхүүн данснаас 138,085.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүйгээр бусад байгууллагад шилжүүлсэн нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,450,063.3 мянган төгрөг болж 53,907.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 18,857.7 мянга, Онцгой байдлын ерөнхий газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 36,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 13,282.2 мянган төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгсэл, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 98 дугаар захирамжаар 9,722.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Жаргалант сумын Засаг даргын 2022 оны А/77 дугаар захирамжаар 14751.4 мянган төгрөгийн өртөг бүхий газар, 2022 оны А/170 дугаар захирамжаар 14,401.6 мянган төгрөгийн өртөг бүхий газар, Өлзийт сумын Засаг даргын 2023 оны А/152 дугаар захирамжаар 24,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий газрыг тус тус эзэмшүүлсэнтэй холбоотой байна.

Мөн тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023.06.02-ний өдрийн А-1/1111 дугаар албан бичгээр 180,500.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа ар талын 115 дугаар анги руу шилжүүлж, данснаас хасах шийдвэр гаргасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,258,455.4 мянган төгрөг болж 881,886.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 881,886.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,877,904.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,877,904.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 168,112.0 мянган төгрөгөөр бууруулж 2,709,792.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,709,792.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,701,432.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,701,432.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7,213.7 мянга, хангамж, бараа материалын зардал 54.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 490.4 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70708 Гамшигаас урьдчилан сэргийлэх	2,709,792,400.00	2,701,432,130.00	8,360,270.00	97.3%
2	80801 Үндсэн үйл ажиллагаа	2,705,051,600.00	2,696,691,330.00	8,360,270.00	100.0%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,740,800.00	4,740,800.00	0.00	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 9,669.0 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 540.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 940.0 мянган төгрөг нийт 11,149.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 11,149.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны эхэнд хоол хүнсний зардалд нийт 19,302.9 мянган төгрөг батлагдсанаас Баян баялаг өргөө ХХК-тай 9,302.9 мянга, Хүслэнт нандин шагай ХХК-тай 10,000.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 178,540.1 мянга, гэрэл цахилгааны зардалд 22,520.3 мянга, цэвэр бохир усны зардалд 4,966.9 мянган төгрөг батлагдсанаас RMB ХХК, Баянхонгор Эко дулаан ХХК, Би Эйч Энд Ди ХХК, Бэст хонгор ХХК-иудтай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-иудтай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань-Баянхонгор”ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор Онцгой байдлын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 18/274 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,476,776.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 35,454.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 24,818.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 5,425.2 мянга буюу 24.1%, түлш халаалтын зардлыг 1,760.9 мянга буюу 1.0%, цэвэр бохир усны зардлыг 27.6 мянга буюу 0.6%-иар хэмнэсэн бөгөөд нийт 7,213.7 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллаа.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 2,818,536.5 мянган төгрөгийн 25 мэдээлэл, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 32,737.4 мянган төгрөгийн 148 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 6,155.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж аудитаар 1,232.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 18/120 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,232.8	1	1,232.8	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	1,232.8	1	1,232.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,072.1 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн тайлан нь мөнгөн гүйлгээний тайлангаас 490.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас зарлага 181.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн нь УСНББОУС-12 Бараа материал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Аймгийн Онцгой комиссоос үнэ төлбөргүй олгосон 4,400.0 мянган төгрөгийн өртөг бүхий цахим хурлын төхөөрөмж болох үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, ангилал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 36,052.2 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 354.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4791.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 30,907.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,052.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,766.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын даргын тушаалаар 12 дугаар сард 4 ажилтанд олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж 3,540.8 мянган төгрөгөөс хуулийн дагуу хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 354.1 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны урсгал засвар болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан 4,791.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,155.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 6,155.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж³

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын санхүүгийн тайланд 2016 онд Сод ноён ХХК-тай холбоотой үүссэн авлага бөгөөд хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ч Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2955 дугаартай албан бичгээр гэмт хэргийн шинжгүй хэмээн дүгнэж 2022 оны 184 дугаартай тогтоолоор хэрэг бүртгэлийг хаасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Уг авлагыг хууль, журмын хүрээнд барагдуулах тараар дээд байгууллагатай хамтран данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах, цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу өр, авлага үүсгэхгүй ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 907.1 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 22,089.9 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

³ Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.”Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын 907.1 мянган төгрөгийн и баримтыг 2024.02.10-ны дотор нөхөн шивүүлэх, цаашид худалдан авалтын и баримтад тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	1	4,400.0			1	4,400.0	1	4,400.0		
Санхүүгийн тайланд бүртгээгүй	2	672.1	2	672.1			2	672.1		
Дүн	3	5,072.1	2	672.1	1	4,400.0	3	5,072.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны урсгал засвар болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан 4,791.0 мянган төгрөгийн сэлбэгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.	1	4,791.0			1	4,791.0		
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 907.1 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 22,089.9 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна.	1	907.1					1	907.1
Тус байгууллагын санхүүгийн тайланд 2016 онд Сод ноён ХХК-тай холбоотой үүссэн авлага бөгөөд хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ч Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2955 дугаартай албан бичгээр гэмт хэргийн шинжгүй	1	30,000.0					1	30,000.0

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хэмээн дүгнэж 2022 оны 184 дугаартай тогтоолоор хэрэг бүртгэлийг хаасан байна.								
Байгууллагын даргын тушаалаар 12 дугаар сард 4 ажилтанд олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж 3,540.8 мянган төгрөгөөс хуулийн дагуу хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	1	354.1	1	354.1				
Нийт дүн	4	36,052.2	1	354.1	1	4,791.0	2	30,907.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,155.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		

-----oOo-----